

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Батноров сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/022/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Б.Хуланхатан Утас: 99008827 Цахим хаяг: khulankhatanb@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 498
танай _____-ны № _____-т

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.ОТГОНБАЯР ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Батноров сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Батноров сумын төвлөрүүлэн захирагч нь 2025 онд орон нутгийн төсөвт 813,500.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,116,044.64 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 302,544.4 мянган төгрөгөөр буюу 137.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Батноров сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,039,763.7 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрч 106,479.7 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан. Батлагдсан төсвийг зориулалтын бусаар зарцуулсан, төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн дайчилж төлөвлөөгүй, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг 921,162.7 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, сумын ИТХ-аар батлагдсан татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлээгүй зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Наймдугаар хуралдаанаар сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг 93.0 хувийн гүйцэтгэлтэй “Үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангаас 823,636.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 641,224.2 мянган төгрөгийн 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, Баянбулаг, Баян, Эрдэнэчандмань багийн төвүүдийн засвар, тохижилтын ажлыг гүйцэтгэгч “Архалдай” ХХК гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас хийгдээгүй байна. Иймд ОНХС-аар хийгдэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг хангаж ажиллах шаардлагатай.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан****/мянган төгрөг/**

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,308,471.39	1,611,152.18
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	875,553.3	938,304.82
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	202,156.4	289,927.11
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	230,761.69	382,920.25
5	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,464,544.74	2,626,237.8
6	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,464,544.74	2,626,237.8
7	1.2.2.02 Биет хөрөнгө		2,329,966.9	2,491,659.96
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	134,577.84	134,577.84
9	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		3,773,016.14	4,237,389.98
10	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		-	9,425.9
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		-	9,425.9
12	2.1.1.03 Өглөг		-	9,425.9
13	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,773,016.14	4,227,964.08
14	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		3,773,016.14	4,227,964.08
15	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		512,372.31	512,372.31
16	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		3,173,004.11	3,627,952.05
17	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		87,639.71	87,639.71
18	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		3,773,016.14	4,237,389.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		3,791,467.4	3,778,667.84
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		1,028,741.97	1,038,294.34
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		678,876.56	692,194.89
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		678,876.56	692,194.89
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		54,269.97	91,342.36
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		295,595.44	254,757.09
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	482,395.47	2,740,373.51
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		-	1,740,940.11
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,280,329.97	-
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,568,554.09	2,968,746.23
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		2,568,554.09	2,968,746.23
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,500,177.17	2,911,706.83
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		906,868.26	1,143,195.86
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		112,605.53	143,180.79
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		895,578.83	962,072.25
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		81,717.25	71,307.53
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		4,007.1	2,629
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		91,561.43	71,050.91
19	1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал		27,962	27,050
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		112,325.34	169,865.67
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		267,551.44	321,354.83
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		68,376.92	57,039.4
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,222,913.31	809,921.61
24	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		676,704.33	362,708.66
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(676,704.3)	(362,708.7)
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		546,208.98	447,212.96

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,226,807.16		3,226,807.16
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,226,807.16		3,226,807.16
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	546,208.98		546,208.98
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,773,016.14		3,773,016.14
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,773,016.14		3,773,016.14
6	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,734.99		7,734.99
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,780,751.12		3,780,751.12
8	1.7 Тайлант үеийн үр дүн	447,212.96		447,212.96
9	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,227,964.08		4,227,964.08

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,442,233.64	3,592,002.93
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,028,741.97	1,038,294.34
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	678,876.56	692,194.89
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	54,269.97	91,342.36
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	295,595.44	254,757.09
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	40,293.54	38,301.88
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	213,541.9	214,660.61
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	41,760	1,794.6
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	125,161.71	2,553,708.59
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	125,161.71	176,724.08
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	1,740,940.11
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	636,044.4
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,288,329.97	-
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,447,551.22	2,747,859.63
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,447,551.22	2,747,859.63
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,379,126.21	2,680,751.28
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	906,868.26	1,143,195.86
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,729.93	143,056.39
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	895,578.83	962,072.25
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	70,607.42	65,708.47
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	4,007.1	2,999
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	107,908.35	72,844.91
23	1.1.1.2.01.1.07 Томилт, зочны зардал	27,962	27,050
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	162,179.77	141,015.12
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	91,284.56	122,809.28
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,425.02	67,108.35
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	994,682.42	844,143.29
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	705,781.59	658,391.77
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	705,781.59	658,391.77
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	705,781.59	658,391.77
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(705,781.59)	(658,391.77)
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	123,000
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(123,000.00)
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	288,900.83	62,751.53
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	586,652.47	875,553.3
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	875,553.3	938,304.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,241,258.7	5,793,673.5
11	3.1.01.1.1 Татварын орлого	792,500.0	1,038,294.3
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	602,000.0	692,194.9
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	602,000.0	692,194.9
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	440,000.0	528,757.5
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	114,000.0	101,878.7
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	45,000.0	58,732.3
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	3,000.0	2,826.5
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	15,000.0	91,342.4
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	12,000.0	60,103.4
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	3,000.0	3,680.0
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	-	27,559.0
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	175,500.0	254,757.1
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	24,500.0	38,301.9
118001	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгийн хураамж	5,000.0	5,833.2
118006	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	6,000.0	11,438.8
118009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	13,500.0	21,029.9
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	150,000.0	214,660.6
118101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	150,000.0	214,660.6
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,000.0	1,794.6
118202	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,000.0	1,794.6
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	5,448,758.7	4,755,379.2
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	72,000.0	172,724.1
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	20,000.0	36,891.0
120004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	50,000.0	50,716.0
120010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	1,000.0	44,258.1
120009	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	1,000.0	40,859.0
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	4,740,714.3	3,946,610.7
122003	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	1,706,731.1	1,706,731.1
122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	3,033,983.2	2,239,879.6
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	636,044.4	636,044.4
123002	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	636,044.4	636,044.4
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,080,508.0	6,246,474.1
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	3,072,478.8	5,482,249.9
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,993,079.7	2,672,491.6
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,220,629.7	1,143,195.9
210101	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	597,546.2	578,570.4
210102	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	509,276.0	458,292.6
210103	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	83,200.0	76,248.0
210104	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	30,607.5	30,084.9
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,578.7	143,056.4
210201	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	103,753.6	97,943.3
210202	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	12,206.3	11,228.0
210203	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	6,103.1	6,941.8
210204	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	6,103.1	5,270.2
210205	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	24,412.6	21,673.0
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,071,437.7	978,300.3
210301	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	167,943.7	107,659.0
210302	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	869,134.0	849,427.2
210303	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	34,360.0	21,214.1
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	77,423.3	64,084.1
210401	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	9,001.4	7,510.1
210402	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	52,700.0	45,380.4

210403	3.1.01.2.1.1.4.03	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,610.3	5,723.1
210405	3.1.01.2.1.1.4.05 устгал, ариутгал	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн	1,563.8	-
210406	3.1.01.2.1.1.4.06	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,547.8	5,470.5
2105	3.1.01.2.1.1.5	Нормативт зардал	4,000.0	2,999.0
210503	3.1.01.2.1.1.5.03	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000.0	2,999.0
2106	3.1.01.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	94,755.8	85,512.5
210601	3.1.01.2.1.1.6.01	Багаж, техник, хэрэгсэл	15,105.8	12,947.6
210603	3.1.01.2.1.1.6.03	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000.0	-
210604	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	77,650.0	72,564.9
2107	3.1.01.2.1.1.7	Томилолт, зочны зардал	33,000.0	27,050.0
210702	3.1.01.2.1.1.7.02	Дотоод албан томилолт	33,000.0	27,050.0
2108	3.1.01.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	219,579.7	137,665.1
210801	3.1.01.2.1.1.8.01	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	214,262.8	134,422.8
210802	3.1.01.2.1.1.8.02	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	961.7	-
210803	3.1.01.2.1.1.8.03	Даатгалын үйлчилгээ	1,014.3	1,013.0
210804	3.1.01.2.1.1.8.04	Тээврийн хэрэгслийн татвар	536.4	303.7
210805	3.1.01.2.1.1.8.05	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245.6	121.0
210806	3.1.01.2.1.1.8.06	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,595.4	1,180.0
210807	3.1.01.2.1.1.8.07	Газрын төлбөр	963.5	624.6
2109	3.1.01.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	119,674.8	90,628.3
210901	3.1.01.2.1.1.9.01	Бараа үйлчилгээний бусад зардал	91,233.9	74,398.1
210902	3.1.01.2.1.1.9.02	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,440.9	16,230.2
213	3.1.01.2.1.4	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,399.1	2,809,758.3
2131	3.1.01.2.1.4.1	Засгийн газрын урсгал шилжүүлэг	12,500.0	2,762,531.7
213101	3.1.01.2.1.4.1.01	Засгийн газрын дотоод шилжүүлэг	12,500.0	8,900.0
213103	3.1.01.2.1.4.1.03	Төсвийн санхүүжилт	-	2,753,631.7
2132	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	66,899.1	47,226.6
213204	3.1.01.2.1.4.2.03	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,581.5	4,550.0
213207	3.1.01.2.1.4.2.06	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,797.6	19,797.6
213208	3.1.01.2.1.4.2.07	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,520.0	14,455.0
213209	3.1.01.2.1.4.2.08	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,000.0	8,424.0
22	3.1.01.2.2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	842,286.5	641,224.2
223001	3.1.01.2.2.4	Бусад хөрөнгө	842,286.5	641,224.2
23	3.1.01.2.3	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	165,742.7	123,000.0
230001	3.1.01.2.3.1	Эргэж төлөгдөх зээл	165,742.7	123,000.0
8	3.1.01	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,160,750.7	(452,800.6)
9	3.1	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(2,160,750.7)	452,800.6
7	3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(2,160,750.7)	452,800.6
4	4	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	874,153.3
5	5	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	935,104.8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	50,437.11
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,437.11
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	50,437.11
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	50,437.11
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	50,437.11
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,648.65
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,788.46
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,255.36
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	40,255.36
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,455.36
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	1,624.40
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	1,444.40
210403	1.1.1.2.1.1.4.3 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,850.00
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,850.00
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	29,980.96
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	29,980.96
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800.00
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	800.00
213209	1.1.1.2.1.4.2.8 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	10,181.75
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(10,181.75)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(10,181.75)

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Батноров сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 6 байгууллага, 1 төрийн сан, 2 тусгай сан нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагын санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан байна.

Аймаг дахь Төрийн аудитын газар Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд, “Платиниум прогресс аудит” ХХК Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн.

3.1 Тус сумын харьяа орон нутгийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар:

Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 687,340.2 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илрүүлснээс 43,548.2 мянган төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулж, 643,792.0 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал

1. Хичээл үйлдвэрлэлийн зардлаас Арслан цолтонд хүндэтгэл үзүүлэх, багш нарт урамшуулал, тэмцээн, уралдааны шагналд 4,021.5 мянган төгрөг, байгууллагын дотоод журамд заасны дагуу албан хаагчид олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас ЗДТГ-ын ажилтанд буцалтгүй тусламж, ЕБС төгсөгчдийн урамшуулалд 1,200.0 мянган төгрөг олгож, нийт 6,161.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

2. Гэрээт ажиллагсдын цалингийн зардлаас олон нийтийн цагдааг цалинжуулж 7,638.9 мянган төгрөгийн төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Засаг даргын тамгын газар

1. Санхүүгийн тайланд ахмадын сангийн 4,000.0 мянган төгрөгийн орлогыг бүртгээгүй, эцсийн үлдэгдлийг 1,400.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.
2. Үндсэн хөрөнгийн хураамтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг 4,558.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав.
3. Байгууллагын дотоод журамд заасны дагуу албан хаагчид олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас сумын аварга малчдад 4,500.0 мянган төгрөгийн шагнал олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сан

1. Санхүүгийн тайланд сумын малын тоо толгойн албан татварын орлогын 27,014.5 мянган төгрөгийг ОНХС-ийн санхүүжилтээр тайлагнасныг урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр бүртгэж залруулав.

2. Шилэн дансны Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл хэсэгт 625,491.6 мянган төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Хоршоо хөгжүүлэх сан

1. Зээлийн хүүгийн авлагын 6,575.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд зээлийн авлагаар бүртгэснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

3.2 Тус сумын харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 37,268.3 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс 29,817.7 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 6,175.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1,275.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

Эрүүл мэндийн төв

Аудитаар, алдаа, зөрчил илрээгүй болно.

Соёлын төв

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд 24,956.3 мянган төгрөгийн тохируулга хийгээгүй байсныг зарцуулсан байна.

Ерөнхий боловсролын сургууль

1. Тайлант онд 7 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 5,044.1 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. Мэдээллийн технологийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчин 1,275.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Хүүхдийн цэцэрлэг

1. Үндсэн хөрөнгөнд 2019, 2023 онд орлого авсан 9 компьютерийн 4,861.4 мянган төгрөгийн элэгдэл бодоогүй байсныг нөхөн тооцоолж залруулав.
2. Тайлант онд 3 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 1,131.5 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3.3 Сумын засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Батноров сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 62,931.5 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайланд залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд замд яваа мөнгө 62,931.5 мянган төгрөгийг тусгаагүй байна.

Аудитаар нийт 289,492.1 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч, 12,121.3 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, 277,370.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

3.3.1 Төлбөрийн акт

Байхгүй.

3.3.2 Албан шаардлага

1. Тайланд оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш 246,400.0 мянган төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулсан.
2. Тайлант онд төсвийн тодотгол 1 удаа хийсэн боловч урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлийг 5,855.3 мянган төгрөгөөр, ОНХС-ийн үлдэгдлийг 19,675.4 мянган төгрөгөөр, ХХС-ийн үлдэгдлийг 5,000.0 мянган төгрөгөөр тус тус дутуу төлөвлөсөн.

3.3.3 Зөвлөмж

1. Үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөг 12,121.3 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	2	9,958.7			2	9,958.7	2	9,958.7				
ХХС	1	6,575.0			1	6,575.0	1	6,575.0				
ОНХС	1	27,014.5			1	27,014.5	1	27,014.5				
ОН-ын дүн	4	43,548.2	-	-	4	43,548.2	4	43,548.2	-	-	-	-
Соёлын төв	1	24,956.3			1	24,956.3	1	24,956.3				
СӨБ	1	4,861.4			1	4,861.4	1	4,861.4				
УТ-ын дүн	2	29,817.7	-	-	2	29,817.7	2	29,817.7	-	-	-	-
Батноров ЗД	1	62,931.5	1	62,931.5			1	62,931.5				
ТТЗ-ын дүн	1	62,931.5	1	62,931.5	-	-	1	62,931.5				
Нийт дүн	7	136,297.4	1	62,931.5	6	73,365.9	7	136,297.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан		Хууль, хяналтын байгууллагад	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ИТХ	2	13,800.4			2	13,800.4		0				
ЗДТГ	1	4,500.0			1	4,500.0						
ОНБ-ын дүн	3	18,300.4	-	-	3	18,300.4	-	-	-	-	-	-
СӨБ	1	1,131.5	1	1,131.5				-				
ЕБС	2	6,319.1	1	5,044.1	1	1,275.0						
УТБ-ын дүн	3	7,450.6	2	6,175.6	1	1,275.0	-	-	-	-	-	-
Батноров ЗД	2	43,092.1			1	30,970.8	1	12,121.3				
ТТЗ-ын дүн	2	43,092.1	-	-	1	30,970.8	1	12,121.3	-	-	-	-
Нийт дүн	8	68,843.1	2	6,175.6	5	50,546.2	1	12,121.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ОНХС	1	625,491.6					1	625,491.6
Дүн	1	625,491.6					1	625,491.6
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-						
ОНБ-ын дүн	-	-	-	-	-	-	-	-
	-	-						
УТБ-ын дүн	-	-	-	-	-	-	-	-
Батноров ЗД	1	246,400.0					1	246,400.0
ТТЗ-ын дүн	1	246,400.0	-	-	-	-	1	246,400.0
Нийт дүн	2	871,891.6	-	-	-	-	2	871,891.6

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	6	4	2		4			
2	ОНТС	2		2					
3	ОНӨҮГ								
4	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	9	5	4		5			



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 24

Дугаар 254-А2370452
ХЭА-2026/022/НА-СТА-ТТЗ

Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батноров сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг дарга нь орон нутгийн ерөнхий орлогын дансны урьд оны үлдэгдлээс 5,855,270.00 (таван сая найман зуун тавин таван мянга хоёр зуун далан) төгрөг, ОНХС-ын үлдэгдэл 19,615,408.00 (арван есөн мянга зургаан зуун арван таван мянга дөрвөн зуун найман) төгрөг, БХС-ийн үлдэгдэл 500,049.00 (таван зуун дөчин есөн) төгрөгийг тус тус бүрэн төлөвлөөгүй, ХХС-ийн үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 5,000,030.00 (таван сая гучин) төгрөгөөр илүү төлөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;" 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ"; 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Г.Отгонбаярт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Б.ХУЛАНХАТАН



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 24

Дугаар 255-А2370452

Чингис хот

ХЭА-2026/022/НА-СТА-ТТЗ

Г Зөрчлийг таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батноров сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш 246,400,00.00 (хоёр зуун дөчин зургаан сая дөрвөн зуун мянган) төгрөгийн 3 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Г.Отгонбаярт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Б.ХУЛАНХАТАН